

БАНКНЫ АЖЛЫН ТАЙЛАН 2016

Банкны товч танилцуулга /эрхэм зорилго, хэтийн зорилт, эрхэмлэх зүйлс/

Кредит банк нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 503 тоот тушаалын дагуу банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч, улмаар 1998 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Кредит банк ХХК нь 100 хувийн гадаадын хөрөнгө оруулалттай банк бөгөөд цорын ганц өмчлөгч нь БНКи-р улсын “Харшал Холдингс Лимитед” компани юм.

Эрхэм зорилго:

Харилцагчдад орчин үеийн технологид суурилсан чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хүргэх, хувь нийлүүлэгчдийн ашгийг нэмэгдүүлэх, банкны ажилтнуудыг хөгжүүлэх.

Монгол улсын эдийн засгийн өсөлт, харилцагч иргэд байгууллагуудын хөгжилд дэм үзүүлэх.

Алсын хараа:

Харилцагчдын хүлээлтэнд нийцсэн, өндөр технологид суурилсан, ёс зүй болон эко орчныг дээдэлсэн, Монгол улсынхаа хөгжилд хувь нэмэр оруулсан салбартаа манлайлагч банк болох.

Эрхэмлэх зүйлс:

- ✓ Чадварлаг хүний нөөц
- ✓ Харилцагчид
- ✓ Итгэлцэл
- ✓ Тасралтгүй хөгжил
- ✓ Эв нэгдэл

Харилцагчийн өмнө хүлээх үүрэг, харилцагчдын эрх ашгийг хамгаалах талаар баримтлах бодлогын хэрэгжилт

Кредит банк нь байгуулагдсан цагаасаа харилцагчдаа дээдэлж, тэдний хүсэл сонирхлыг харгалзан үзэж, үйл ажиллагаандаа тусган ажиллахыг эрхэмлэж ирсэн билээ. Иймээс ч Харилцагч нь Кредит банкны “Үнэт зүйлс”-ийн нэг болдог.

Харилцагчдад түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээндээ ёс зүйн зарчмуудыг мөрдөх, харилцагчдын нууцыг хадгалах, тэдний эрх ашгийг хүндэтгэн хамгаалах, харилцагчдынхаа итгэлийг хүлээсэн санхүүгийн найдвартай хамтран дэмжигч байх нь бидний харилцагчдынхаа өмнө хүлээсэн үүрэг билээ. Кредит банкны уриа нь “Та бидний итгэлцэл” бөгөөд бид харилцагчид, түншүүд болон банкны удирдлага, хамт олны хоорондын итгэлцлийн харилцаан дээр тулгуурлан үйл ажиллагаагаа явуулж байна.

Банкны зохистой засаглалын талаар баримтлах зарчим, бодлогын хэрэгжилт

Кредит банк нь үйл ажиллагаандаа компанийн засаглал, бизнесийн ёс зүйн зарчмуудыг баримталж, хэрэгжүүлэхийг эрмэлздэг ба өөрийн үйл ажиллагаагаа Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А-151 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журмыг хэрэглэх зөвлөмж”-д нийцүүлэн явуулж, холбогдох тайлан мэдээг тогтмол гарган Монголбанкинд хүргүүлж байна.

Банк нь зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлж ажилласнаар ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын зүгээс банк ба банкны хувь нийлүүлэгчийн өмнө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх, ТУЗ-өөс гүйцэтгэх удирдлагад тавих үр дүнтэй хяналтыг сайжруулах, гүйцэтгэх удирдлагын шийдвэр гаргалтын чанар, хариуцлагыг нэмэгдүүлэх, банкны дунд ба урт хугацааны стратегийн төлөвлөлтийг хувь нийлүүлэгч болон ТУЗ-өөс чиглүүлэн дэмжих үр ашигтай бөгөөд энэ нь банк урт хугацаанд тогтвортой хөгжих үндэс болж байна.

Бид ил тод, нээлттэй байх зарчмын хүрээнд банкны бүтэц зохион байгуулалт, ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллээ тогтмол шинэчлэн банкны цахим хуудсанд байршуулж байна. Банкны санхүүгийн болон шаардлагатай бусад тайлан мэдээг банкны цахим хуудсанд байршуулахаас гадна мөн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлж байна.

Бизнесийн үйл ажиллагааны онцлох үзүүлэлтүүдийн өөрчлөлт болон тайлбар

Банк 2016 онд зээлийн багцын чанарыг хадгалах, банкны бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлийг шинэчлэх, харилцагчдын тоог нэмэгдүүлэх, Монголбанкнаас тавьсан шаардлагыг биелүүлэх болон хөрөнгийн хэмжээг өсгөхөд анхаарч ажиллалаа.

Банк 2016 онд 555,4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллав.

Банкны Дүрмийн санг 4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн.

2016 оны санхүүгийн үзүүлэлтийг 2015 оны үзүүлэлттэй харьцуулсан харьцуулалтыг доорх хүснэгтэнд харууллаа:

Сая төгрөгөөр

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2015 он	2016 он	Өөрчлөлт
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	10,794.7	11,065.2	270.5
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	19.8	1,040.9	1,021.1
Зээл, цэвэр	4,838.2	4,138.8	(699.3)
Бусад актив хөрөнгө	105.2	101.6	(3.6)
Үндсэн хөрөнгө, цэвэр	838.0	882.9	44.9
АКТИВ ХӨРӨНГӨ	16,595.8	17,229.4	633.6
Харилцах данс	96.9	160.0	63.1
Хугацаагүй хадгаламж	80.7	76.6	(4.1)
Хугацаатай хадгаламж	19.5	18.8	(0.7)
Бусад пассив	4,005.1	16.8	(3,988.3)
Хувь нийлүүлсэн хөрөнгө	16,090.0	20,090.0	4,000.0
Дахин үнэлгээний нэмэгдэл	396.7	396.7	-
Хуримтлагдсан алдагдал	(4,100.8)	(4,109.0)	(8.2)
Тухайн жилийн ашиг	7.7	555.4	547.7
Бусад өөрийн хөрөнгө	0.1	24.1	24.0
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ БА ПАССИВ	16,595.8	17,229.4	633.6

Кредит банкны 2016 оны орлогын тайлан

Сая төгрөгөөр

Үзүүлэлтүүд	2016 он
Орлого	
Хүүгийн орлого	1,668.3
Ханшийн тэгшиггэлийн цэвэр орлого	959.8
Бусад орлого	53.1
Нийт орлого	2,681.2
Зардал	
Хүүгийн зардал	8.5
Валют арилжааны алдагдал	53.8
Үйл ажиллагааны зардал	1,727.8
Бусад зардал	91.6
Болзошгүй эрсдлийн зардал	244.0
Нийт зардал	2,125.8
Орлогын татварын өмнөх ашиг	555.4
Орлогын татварын зардал	-
Тайлант жилийн цэвэр ашиг	555.4
Бусад хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлт	24.0
Тайлант жилийн нийт орлогын дүн	579.4

Банкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны тайлан

Кредит банкны Эрсдэлийн удирдлагын хэлтэс нь Гүйцэтгэх захирлын шууд удирдлаган дор ажилладаг хараат бус, бие даасан нэгж бөгөөд тайлант хугацаанд дараах чиглэлээр хяналт тавьж, Гүйцэтгэх удирдлага, АПЭУХороо болон ТУЗ-ийн дэргэдэх ЭУХ-нд тайлагнан ажиллалаа. Үүнд:

- Банкны нийт харилцагчид, хувь нийлүүлэгчид, ТУЗ-ийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагын хүрээнд эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог нэвтрүүлэх, батлагдсан эрсдэлийн хязгаарын хүрээнд хяналт тавих;
- Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй санхүүгийн эрсдэл, зах зээлийн, хөрвөх чадварын, зээлийн, үйл ажиллагааны, хуулийн, нэр хүндийн зэрэг эрсдэлүүдийг холбогдох арга, аргачлалыг ашиглан тодорхойлох, хэмжих, үнэлэх, тайлагнах;
- Эрсдэлийн удирдлагын бодлого, журам, зааврыг боловсронгуй болгох, мөрдөх, хэрэгжилтэнд хяналт тавих;
- Зээлийн газар болон Хуулийн хэлтэстэй хамтран хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлд хяналт тавих, төлүүлэх, бууруулах.

Санхүүгийн эрсдэл

Банкны санхүүгийн эрсдэлийн хүрээнд өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтүүд, ашигт ажиллагаа, хөрвөх чадварын эрсдэлд хяналт тавьж, холбогдох тайлан, дүгнэлтийг гарган удирдлагад болон холбогдох хорооны хуралд танилцуулан ажиллаж байна.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ:

Тайлант хугацаанд банкны дүрмийн сан 4.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээр өөрийн хөрөнгийн хэмжээ 36.63%-иар өссөн ба 2016 онд Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтүүдийн зохистой харьцааг бүрэн ханган ажилласан байна:

№	Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтүүд	2015	2016
1	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа > 12%	195.32%	130.50%
2	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа > 6%	189.07%	127.44%
3	Хөшүүргийн харьцаа > 7%	72.29%	96.11%

Ашигт ажиллагаа:

2016 оны 12 сарын 31-нээр банкны ашигт ажиллагааны үзүүлэлтүүд тухайн онд 555.4 сая төгрөгийн ашигтай ажилласнаар активын өгөөж /ROA/ болон өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/, ахиуц өгөөж, цэвэр ахиуц ашиг бүгд өссөн байна.

№	Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд	2015	2016
1	Активын өгөөж	0.05%	3.22%
2	Өөрийн хөрөнгийн өгөөж	0.06%	3.28%
3	Цэвэр ахиуц ашиг	0.41%	13.57%

Хөрвөх чадварын эрсдэл:

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	2015	2016
1	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа > 25%	257.5%	4,028.2%
2	Богино хугацааны актив, пассивын зөрүү болон богино хугацаатай пассивын харьцаа	6,097.7%	4,764.4%

2016 онд банк нь хөрвөх чадварын эрсдэлийн үзүүлэлтүүд болох Монголбанкнаас тогтоосон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаанууд, зайлшгүй байх нөөцийн шаардлагыг тогтмол ханган ажиллалаа.

Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэлийн хүрээнд ханшийн эрсдэл, хүүгийн эрсдэл, үнийн эрсдэлийг тодорхойлон хяналт тавьж ажиллаж байна. Зах зээлийн эрсдэлээс сэргийлэх үүднээс Эрсдэлийн удирдлагын хэлтсээс эдийн засгийн нөхцөл байдал, макро болон микро орчинд гарч байгаа болон гарах өөрчлөлтийн талаарх судалгааг улирал бүр хийж Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн ЭУХороонд танилцуулан ажиллаж байна.

Ханшийн эрсдэл:

Банк нь Монголбанкнаас тогтоосон Гадаад валютын актив, пассивын зохистой харьцааг нэгж болон нийт валютын хувьд 2016 онд тогтмол ханган ажилласан.

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	2015	2016Q4
1	Гадаад валютын актив, пассивын зохистой харьцаа /нэгж валют < +/-15%/	1.66%	14.19%
2	Гадаад валютын актив, пассивын зохистой харьцаа / нийт валют < +/-40%/	2.11%	37.69%

Хүүгийн эрсдэл:

Хүүгийн эрсдэлийг тодорхойлох үүднээс ЭУХэлтсээс хүүд мэдрэмжтэй актив, пассивын зөрүүгийн шинжилгээ, цэвэр хүүгийн зөрүүгийн харьцаа, хугарлын цэгийн шинжилгээ зэргийг хийж санал, дүгнэлтийг холбогдох хорооны хуралд танилцуулан ажиллалаа.

Үнийн эрсдэл:

2016 онд банкны тэнцэлд үнийн эрсдэлд өртөх санхүүгийн хэрэгсэл байхгүй ч барьцаа хөрөнгийн үнийн хувьд зах зээлд гарч байгаа өөрчлөлт, үнийн өсөлт, бууралтын хандлагын талаарх судалгааг хийж санал, дүгнэлтийг холбогдох хорооны хуралд танилцуулж байна.

Зээлийн эрсдэл

Зээлийн багцын хяналт хийх үйл ажиллагааны хүрээнд сар бүр банкны Зээлийн бодлого болон Монголбанкнаас тогтоосон зээлийн хязгааруудын биелэлт, зээлийн төвлөрлийн эрсдэл, зээлийн багцын чанарт хяналт тавин ажиллалаа.

Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийг төлүүлэхэд Зээлийн газар болон Хуулийн хэлтэстэй хамтран ажиллаж 7 хоног бүр тайланг гарган удирдлагад танилцуулж ирлээ.

2016 онд банкны Зээлийн бодлого болон Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааг бүрэн ханган ажилласан.

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	2015	2016
1	Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээл, өөрийн хөрөнгөд эзлэх хувь < 20%	0.76%	0.64%
2	Банкны хувь нийлүүлэгч, ажилтан, тэдгээрт холбогдох этгээдэд олгосон зээл, өөрийн хөрөнгөд эзлэх хувь / нийт < 20%, нэг зээлдэгч < 5%/	0.92%	0.40%
		2.37%	0.83%
3	20 том зээл, нийт зээлийн харьцаа < 50%	24.93%	30.38%

Бусад эрсдэл

Банкны үйл ажиллагааны эрсдэл, хуулийн эрсдэл, нэр хүндийн эрсдэлийн хүчин зүйлийн үнэлгээг холбогдох журамд заасны дагуу тогтмол хугацаанд шинэчилж эрсдэлийн үзүүлэлтүүдийн нэгдсэн үнэлгээ дүгнэлтийг сар бүр Гүйцэтгэх удирдлагад танилцуулан ажиллалаа. Эдгээр эрсдлүүдийн хүрээнд 2016 онд томоохон зөрчил, дутагдал, хохирол гараагүй байна.

Мэдээллийн технологийн үйл ажиллагааны тайлан

2016 онд банкны мэдээлэл технологийн найдвартай ажиллагааг хангах хүрээнд сервер тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, үндсэн бүртгэлийн програм хангамжын шинэчлэлтүүд, дотоодын үйл ажиллагааны хэрэгцээнд шинэ програм хангамжуудыг нэвтрүүлэх, програм хангамжийн ашиглалтыг сайжруулах зэрэг ажлуудыг хийлээ.

Арилжааны банкны бүртгэл хөтлөлтийн үндсэн зарчмаа олон улсын стандарт/СТОУС/-д нийцүүлэн тайлан мэдээгээ гаргадаг болсон.

Банкны харилцагчдын гүйлгээг хялбар болгох үүднээс Интернэт банк системийг нэвтрүүлэх ажлын судалгааг хийж, төсөв гарган ТУЗ-д танилцуулаад байна. 2017 ондоо нэвтрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Хүний нөөцийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт

Кредит банк нь мэргэжлийн, ур чадвартай ажилтнаар хүний нөөцөө бүрдүүлэх бодлого баримталж байна. Банк нь ажилтнуудаа урт хугацаанд тогтвор суурьшилтай ажиллуулах, эрүүл, аюулгүй ажлын байрны нөхцөлөөр хангах, нийгмийн баталгааг сайжруулах зэрэг асуудлыг шийдвэрлэн ажилладаг. Мөн ажилтныхаа ёс зүйг төлөвшүүлэх, идэвх санаачилга, урам зоригтой ажиллах, өөрийгөө хөгжүүлэх, мэргэшин суралцахыг дэмждэг.

Кредит банк нь ажилтан шалгаруулж авахдаа нийтэд нээлттэй, ил тод, шударга байдлыг эрхэмлэдэг. Гарсан ажлын байрны зарыг тухай бүрт нь www.creditbank.mn, www.biznetwork.mn цахим хуудсанд байршуулдаг. Ажилтнуудаа Монголын болон олон улсын их дээд сургуулийг банк, санхүү, нягтлан бодох бүртгэлээр амжилттай төгсөж, Кредит банкны сонгон шалгаруулалтын шалгалтад тэнцсэн байх шаардлага тавьдаг бөгөөд орос, англи хэлийг тухайн мэргэжлийн ажил гүйцэтгэх түвшинд эзэмшсэн, ёс зүйн хувьд төлөвшсөн, судалгаа хийж дүгнэлт гаргах, бодлогын баримт бичиг боловсруулах чадвартай байх гэсэн шалгуураар сонгон шалгаруулж авдаг юм.

Компанийн нийгмийн хариуцлага, Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилт

Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд 2016 онд тус банк дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Монголын банкны холбоо, арилжааны банкуудаас зохион байгуулсан Тогтвортой санхүүжилтийн туршлага судлах арга хэмжээ, ажлын хэсгийн өргөтгөсөн уулзалтууд, бусад арга хэмжээнд тогтмол хамрагдлаа.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, жирэмсэн болон өндөр настнуудад дараалал харгалзахгүй үйлчилж байна.
- Тэргэнцэртэй иргэдэд зориулсан зам, гарцыг бий болгосон.
- Тогтвортой Санхүүжилт хөтөлбөрийн 8 зарчим, 4 салбарын удирдамжийн хүрээнд банк нь өөрийн зээлийн болон эрсдэлийн бодлого, журам, заавруудаа өөрчлөлт оруулж, ToC хөтөлбөрийн хүрээнд харилцагчдад тавигдах тусгай шаардлагуудыг бодлого заавартаа тусгасан.
- Банкны харилцагчийн эрсдэлийг тооцоолохоос гадна өөрсдөө нийгэмд үлгэр дуурайлал үзүүлэх зорилгоор “Үлгэрлэн манлайлах зарчим”-ыг баримталж, ус, цаас, эрчим хүчийг хэмнэх үйл ажиллагааг 2016 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн байна.

Гадаад болон дотоодын салбар нэгжийн тоо, байршил, үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Кредит банк нь өөрийн төв байрандаа үйл ажиллагаа явуулж байна. Мөн ОХУ болон БНСУ-ын банкуудаар дамжуулан гадаад төлбөр тооцооны үйлчилгээг харилцагчиддаа хүргэж байна.

“Кредит банк” ХХК-ийн
Гүйцэтгэх Захирал



А.С.Кравцов